



УИХ-аас “Замын хөдөлгөөний аюулгvй байдлын тухай хууль”-ийг шинэчлэн баталсан бөгөөд Хууль зvйн сайдын тушаалаар “**Жолоочийн зөрчлийн бvртгэлийн оноо тооцох журам** ”-ыг баталсан. Энэ журам нь 2016 оны 2 сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхлээд байна.

Жолоочийн зөрчлийн бvртгэлийн оноо тооцох нь зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлж, учрах хохирлыг багасгах, жолооч нарын сахилга хариуцлагыг дээшлvvлж, замын хөдөлгөөнд соёлтой оролцуулахад чиглэгдсэн бөгөөд зөвхөн хасах биш зөрчил гаргаагvй тохиолдолд урамшуулах асуудлыг зохицуулж өгсөн.

Журамд зааснаар зөрчлийн онооны дээд хэмжээ 10 байхаар заасан бөгөөд ЗХАБ-тай холбоотой хууль, тогтоомж, дvрэм, журам, стандарт зөрчсөн vйлдэлд холбогдох хуулийн дагуу торгох шийтгэл ногдуулж, зөрчлийн оноог дараах хэмжээгээр хасахаар заасан:

## 1 оноо хасах тохиолдлууд

- Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгvй этгээдэд жолоог шилжvvлсэн жолооч /192.000/

- Замын хөдөлгөөний аюулгvй байдлыг хангаж чадахааргvй өвчтэй буюу ядарсан vедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, мөн этгээдэд тээврийн хэрэгслийн жолоог шилжvvлсэн жолооч /48.000, 19.200/

- Замын хөдөлгөөнд оролцохдоо хамгаалах бvс, хамгаалах малгай хэрэглээгvй жолооч /9.600/

- Замын хөдөлгөөнд оролцохдоо зорчигчид хамгаалах бvс, хамгаалах малгай хэрэглvvлээгvй жолооч /9.600/

- Гэрлэн дохио болон цагдаагийн алба хаагчийн хориглосон дохиог зөрчин замын хөдөлгөөнд оролцсон жолооч /19.200/

- Тууш замын хөдөлгөөний журам зөрчсөн жолооч /19.200/

- Хvн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн жолооч /96.000, 192.000/

## 2 оноо хасах тохиолдлууд

- Тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох vнэмлэхгvй vедээ тээврийн хэрэгсэл жолоодсон жолооч /192.000/

- Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл хэрэглэсэн этгээдэд жолоог шилжvvлсэн жолооч /96.000/

- Улсын бvртгэлийн дугааргvй, тогтоосон хугацаанд дугаараа аваагvй буюу дугаараа нуун далдалсан тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцсон жолооч /96.000/

- Зам тээврийн осолд холбогдсон жолооч ЗХД-д заасан vvргээ биелvvлээгvй жолооч /96.000/

- Замын хөдөлгөөний дvрэмд зааснаар гvйцэж тvрvvлэхийг хориглосон газарт гvйцэж тvрvvлэх vйлдэл хийсэн жолооч /19.200/

- Замын хөдөлгөөний дүрэмд заасан тээврийн хэрэгслийн хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас тавь хүртэл хувиар хэтрүүлсэн жолооч /19.200/

- Давуу эрх бүхий явган зорчигчид зам тавьж өгөөгүй жолооч /9.600/

- Механикжсан ТХ-ийн ажлын тоормозны систем, жолооны механизм ажиллахгүй, чиргүүлийн холбоос эвдэрсэн, харанхуй буюу үзэгдэх орчин хязгаарлагдмал үед гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл нь бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон жолооч /48.000/

## 3 оноо хасах тохиолдлууд

- Төмөр замын гарам нэвтрэх журам зөрчсөн жолооч /48.000/

- ТХ-ийн тусгай дуут болон гэрлэн дохио тавьж, ашиглахтай холбоотой, хууль тогтоомж зөрчсөн жолооч /96.000/

## 5 оноо хасах тохиолдол

- Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг зөрчсөноос зам тээврийн осол үйлдсэн болох нь эрх бүхий байгууллага, албан тушаалтны хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд буруутай жолоочоос хасна.

**Зөрчлийн оноо хасагдсанаас хойш 1 жилийн хугацаанд дахин ЗХАБТХ, тогтоомж зөрчөөгүй жолоочийн хамгийн сүүлийн хасагдсан оноог сэргээж, мөн зөрчил гаргалгүй 2 жил өнгөрсөн тохиолдолд 10 оноог**

**сэргээж урамшуулна гэж заажээ.**

*(Мэдээллийн эх сурвалж: Замын Цагдаагийн Газар)*

## Жолоочийн Зөрчлийн 10 Онооноос Ямар Тохиолдолд Хасах Вэ?


Жолоочийн зөрчлийн 10 оноог ямар
тохиолдолд хэдийг хасах вэ?
Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийг зөрчсөнөөс зам тээврийн осол үйлдсэн болох нь эрх бүхий байгууллага, албан тушаалтны хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд 5 оноо хасна.
-5
Тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох үнэмлэхгүй
/жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/ тээврийн х
жолоодсон жолоочид -2 оноо.
Жолоочийн үнэмлэх
"B"
-2
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээдэд /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/ тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн тээврийн хэрэгслийн жолоодох эрхтэй жолоочид -1 оноо.
-1
Согтууруулах ундаа, мансуурулах эм, сэтгэцэд нө
бодис хэрэглэсэн этгээдэд тээврийн хэрэгслийн жо
шилжүүлсэн жолоочид -2 оноо.



Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, мөн уг этгээдэд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн жолоочид -1 оноо.





Механикжсан тээврийн хэрэгслийн ажлын тоормосны си
жолооны механизм ажиллахгүй, чиргүүлийн хо
/чиргүүлтэй үед/ эвдэрсэн, харанхуй буюу үзэгдэх
хязгаарлагдмал үед гадна талын гэрэлтүүлэх хэрэгс
бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөл
оролцсон жолоочид -2 оноо.

-2





Улсын бүртгэлийн дугааргүй, тогтоосон хугацаанд дугаараа аваагүй буюу дугаараа нуун далдалсан тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцсон жолоочид -2 оноо.



-2

Зам тээврийн осолд холбогдсон жолооч Замын хөдөлгөөний дүрэмд заасан үүргээ биелүүлээгүй жолоочид -2 оноо.


Тээврийн
тусгай дуут
гэрлэн дохио
ашиглахтай
хууль,
зөрчсөн жолоочид
оноо.
Замын хөдөлгөөнд оролцохдоо хамгаалах бүс, хамгаалах малгай хэрэглээгүй, зорчигчид хамгаалах бүс, хамгаалах малгай хэрэглүүлээгүй жолоочид -1 оноо.
-1
Замын хөдөлгөөний дүрэмд заасан тээврийн хэрэгслийн хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас тавь хүртэл хувиар хэтрүүлсэн тохиолдолд -2 оноо.
-2
60
150
Гэрлэн дохио болон цагдаагийн алба
хориглосон дохиог зөрчин замын
оролцсон жолоочид -1.
-1




*(Мэдээллийн эх сурвалж: Gogo.mn)*